



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он... дугаар  
сарын...-ны өдөр

Дугаар ХТТ/3024

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Н.АЛТАНХУЯГ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих талаар Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан Хөгжлийн банкнаас олгосон зээлийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Сангийн яамнаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт: ... хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225017141



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С Данзэнгийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс (976-51) 26 74 68, И-мэйл info@mof.gov.mn  
Вэбсайт www.mof.gov.mn

2022.12.09 № 03/8383  
танай 2022.11.18 -ны № 437/2811 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА  
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА


Асуулгын хариу  
хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих талаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай болон Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Монгол Улсын Хөгжлийн банкнаас бэлтгэн ирүүлсний дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Уг асуулгад дурдсан асуудлаар Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Хөгжлийн банкны холбогдох албан тушаалтнуудад үүсгэсэн эрүүгийн хэргийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3-т хохирогч нь мэдээллийг задруулахгүй байх, 3.4-т хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам сахих үүрэгтэй гэж тус тус заасныг анхаарахыг Танаас хүсье.

Хавсралт 7 хуудас.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ

9766017845

**ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТАЛААР  
ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ БОЛОН  
ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТАЛААР**

1. Хөгжлийн банктай холбогдуулан гаргасан Засгийн газрын тогтоолуудад дурдагдсан аж ахуйн нэгжүүд болон нийт төслийн хэдэн хувьд нь тус банк санхүүжилт олгосон талаар /2013-2016 он/

Төсөл хэрэгжүүлэгч	ЗГ-ын тогтоол	Тогтоолын дүн (1)	Олгосон дүн (2)	Олголтын хувь (2)/(1)
Бэрэн групп ХХК	2013-256	22.7 сая \$	22.7 сая \$	100.0%
Мон-Лаа ХХК	2013-256, 2014-41	6.4 сая \$	3.0 сая \$ тэнцэх төгрөг*	47.2%
Монголросцветмет ХК	2013-256	12.1 сая \$	санхүүжилт аваагүй	0.0%
Монгол Метал Майнинг Холдинг ХХК	2013-256	8.8 сая \$	санхүүжилт аваагүй	0.0%
<b>Нийт дүн</b>		<b>50.0 сая \$</b>	<b>25.7 сая \$</b>	<b>51.4%</b>

\*Гэрээ байгуулах үеийн МБ-ны албан хани (1\$=1869.77)-аар 5.6 тэрбум төгрөгийг олгосон байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжих зорилгоор төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжих тухай 2013 оны 256 дугаар тогтоолын хүрээнд нийт 4 компанид 50.0 сая ам.доллартой тэнцэх санхүүжилтийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхийг зөвшөөрсний дагуу 2 төсөл хэрэгжүүлэгчид нийт 25.7 сая ам.доллартой тэнцэх санхүүжилтийг олгосон байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн “Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих тухай” 256 дугаар тогтоолын биелэлтийн талаар

Тогтоолын хүрээнд “Бэрэн групп” ХХК болон “Мон-Лаа” ХХК-д 25.7 сая ам.доллартой тэнцэх санхүүжилтийг олгосон ба тогтоолоор олгоогүй чөлөөт үлдэгдлийг Засгийн газрын 2015 оны 171 дүгээр тогтоолоор ноолуурын салбарын төсөл хөтөлбөрт зарцуулахаар татсан байна.

3. Уг тогтоол нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдөр гаргасан “Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай” 28/20 тоот зөвлөмжийг хангаж чадсан эсэх

Монгол Улсын Хөгжлийн банк нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж хангагдсан эсэх талаар дүгнэлт өгөх боломжгүй бөгөөд уг асуудлыг холбогдох төрийн байгууллага болон хууль, хяналтын байгууллага хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд тогтоох боломжтой.

4. Уг тогтоолд заасан “Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэр болон Барилгын арматурын үйлдвэрийг барьж байгуулахад шаардлагатай байгаа 50.0 (тавин) сая хүртэлх ам.доллартой тэнцэх төгрөгийн санхүүжилтийг хавсралт ёсоор баталсугай.” гэсэн нь Хөгжлийн банк энэ дөрвөн зэргийг заавал олгох ёстой эсэх талаар

Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Монгол Улсын Хөгжлийн банк”-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг батлахаар заасан боловч тус заалт бүрэн хэрэгжээгүй бөгөөд Засгийн газар

Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчийн хувиар Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг Засгийн газрын тогтоолоор баталж байсан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсэгт хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй гэж заасны дагуу Хөгжлийн банкны Зээлийн удирдлагын хороо болон ТУЗ-өөс Засгийн газрын 2013 оны 256 дугаар тогтоолын дагуу холбогдох зээл олгох шийдвэрийг гаргаж зээлийг олгосон байна.

**5. Хөгжлийн банк дээрх тогтоолд дурдагдсан 4 аж ахуйн нэгжээс хэдэн аж ахуйн нэгжид хэдэн төгрөгийн зээл /ам.доллар/ олгосон, хэдэн аж ахуйн нэгжид зээл олгоогүй /хэдэн ам.доллар/ талаар**

Засгийн газрын 2013 оны 256 тогтоолын хүрээнд “Бэрэн групп” ХХК-ийн Орхон аймагт хэрэгжүүлэх жилд 100,000 тонн барилгын арматур үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр барьж байгуулах төслийн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 8 дугаар тогтоолоор 22.7 сая ам.долларын санхүүжилтийг зээлийг олгохоор шийдвэрлэж олгосон байна.

Засгийн газрын 2013 оны 256, 2014 оны 41 дүгээр тогтоолын хүрээнд “Мон-Лаа” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр”-ийн төсөлд зориулан Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 52 дугаар тогтоолоор 3.0 сая ам.доллартой тэнцэх 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэж олгосон байна.

“Монголросцветмет” ХК-ийн Ерөнхий захирал Х.Болор-Эрдэнэд 2014.05.15-ны өдрийн 6/328 тоот албан бичгээр Хөгжлийн банкны Зээлийн хорооны хурлаас гарсан шийдвэр буюу санхүүжилт олгоход хангуулах шаардлагыг хүргүүлсэн байна. Харилцагчийн зүгээс банкнаас тавьсан шаардлагыг хангаж ирүүлээгүй буюу санхүүжилтийг аваагүй байна.

“Монгол Метал Майнинг Холдинг” ХХК-ийн зүгээс санхүүжилтийн судалгаа, шинжилгээ хийхэд шаардлагатай материалыг Хөгжлийн банканд ирүүлээгүй буюу санхүүжилтийг аваагүй байна.

**6. Хөгжлийн банкны зээл олгосон аж ахуйн нэгж болон хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд нь тус банкны хуульд заасан шаардлагыг хангаж байсан эсэх /барьцаа хөрөнгө, өөрөө босгох хөрөнгөө хэрхэн бүрдүүлсэн/ талаар**

“Мон-Лаа” ХХК нь анх зээл олгогдох үед Хаан банканд 7.6 сая ам.долларын хугацаа хэтэрсэн зээлийн өртэй, зээлийн муу түүхтэй байсан бөгөөд зээлийн нийт барьцаа хөрөнгийн 65.3 хувь нь хөндлөнгийн, хамааралгүй аж ахуйн нэгжийн барьцаа ба үүнээс худалдан авах тоног төхөөрөмж, борлуулалтын орлого нь Хаан банканд давхар барьцаалагдсан байсан нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Зээлийн үйл ажиллагааны журам, Эд хөрөнгө барьцаалах журмын шаардлагыг хангаагүй.

“Бэрэн групп” ХХК-ийн хувьд тус компанид анх зээл олгохдоо барьцаа хөрөнгийн 35.5 хувийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, 47.4 хувийг ирээдүйд бий болох хөрөнгөөр /тоног төхөөрөмж/ бүрдүүлсэн нь тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан “Эд хөрөнгө барьцаалах журам”-д “нэг төрлийн барьцаа хөрөнгийг их хэмжээгээр хүлээн авах нь төвлөрлийн эрсдэлийг нэмэгдүүлнэ” гэж заасныг зөрчсөн. Ашигт малтмалын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай зөвшөөрлийг эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, геологийн судалгааны мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг холбогдох баримт бичиг болон хууль тогтоомжоор барьцаалахыг хориглоогүй эд хөрөнгийн хамтаар банк, банк бус санхүүгийн байгууллагад, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн татварын өрийг хураах зорилгоор татварын албанд барьцаалж болох бөгөөд тусгай зөвшөөрөл нь дангаараа барьцааны зүйл болохгүй.” гэж заасан боловч

Хөгжлийн банкнаас байгуулсан барьцааны гэрээнд зөвхөн тусгай зөвшөөрлүүдийг барьцаалсан нь дээрх хуулийн шаардлагыг хангаагүй.

Мөн Авлигатай тэмцэх газраас Хөгжлийн банкнаас төсөл, хөтөлбөрүүдэд зээл олгох явцад авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, зээлийн бодлого, журам зэрэг хууль тогтоомжийн дагуу олгосон эсэх, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх зэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Нийслэлийн прокурорын газарт шилжүүлсэн байгаа тул хууль хяналтын болон шүүхийн байгууллагаас уг асуудлыг эцэслэн тогтоохоор байна.

**7. Зээл олгосон дээрх 2 аж ахуйн нэгжийн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон зээлийг төлүүлэх талаар Хөгжлийн банкнаас авсан арга хэмжээний талаар**

Д/д	Зээлийн гэрээний дугаар	Гэрээ байгуулсан өгнөө	Санхүүжилтийн нийт дүн /USD/	Зээл төлөлтийн мэдээ /USD/			
				Үндсэн зээл	Үндсэн хүү	Нэмэгдүүлсэн ХҮҮ	Нийт төлсөклүн
1	З-АУ-ХО 2014-11	2014/02/12	22,699,550	-	2,207,107	110,970	2,318,077
2	ЗГ-АУ-З 2018-68	2018/5/24	4,500,000	-	-	-	-
3	З-БГ-ЗҮ 2017-180	2017/10/19	11,652,227	169,631	959,765	302	1,129,698
Нийт дүн			38,851,777	169,631	3,166,872	111,273	3,447,776

Монгол Улсын Хөгжлийн банк нь арматурын нийт зээлийн өр төлбөрийг төлүүлэх, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд холбогдох нэхэмжлэлийг 2022 оны 8 дугаар сарын 9-ний өдөр хүргүүлсэн ба өнөөдрийн байдлаар шүүх хурлын тов зарлагдаагүй, банк нэхэмжлэлийн шаардлагыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөр нэмэгдүүлж “Бэрэн групп” ХХК-с 146,477,966,616 төгрөгийг гаргуулахаар нэхэмжилсэн.

Банк тухайн зээлийн нийт өр төлбөрийг шүүхийн шийдвэрээр баталгаажуулах, дараагаар шүүхийн шийдвэрийн хүрээнд өр төлбөрийг боломжит богино хугацаанд бүрэн барагдуулах зорилт тавин ажиллаж байна.

Тус зорилтын хүрээнд нийт өр төлбөрийг барагдуулах тухай хэлцлийг хийхээр “Бэрэн групп” ХХК-ийн хувьцаа эзэмшигч, ерөнхий захирал болон гүйцэтгэх захирлуудтай удаа дараагийн уулзалт хийсэн. Уулзалтаар зээлдэгчийн зүгээс арматурын үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж буй “Бэрэн металл” ХХК-ийн хувьцаа, компанийн эрхийг банканд шилжүүлэхээр ярилцсан ба үүний дагуу “Бэрэн металл” ХХК-ийн бусдад эзэмшүүлсэн хувь эзэмшил, банканд барьцаалагдсан асуудлуудыг цэгцлэх шаардлагыг тавьж, компанийн хувьцаа, бүтцэд өөрчлөлт оруулах замаар зээлийн өр төлбөрийг шийдвэрлэх хэлэлцээрийг хэрэгжүүлэх боломжийг бий болгохыг шаардан ажилласан.

“Бэрэн групп” ХХК нь 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 220 дугаартай албан бичгээр “Бэрэн металл” ХХК-ийн 100%-ийн хувьцаа, компанийн эрхийг шилжүүлж Хөгжлийн банкны нийт /арматур+ Хангай хотхоны орон сууц/ өр төлбөр болох 174.8 тэрбум төгрөгийн өрийг хаах тухай саналыг ирүүлсэн. Хөгжлийн банк нь “Бэрэн металл” ХХК-ийн хувьцаа болон компанийн эрх шилжүүлэхтэй холбоотой судалгааг хийж байгаа бөгөөд төслийн газар дээрх хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгүүдийг үзсэн.

“Бэрэн металл” ХХК-ийн нийт хөрөнгийн үнэлгээг хийж байгаа бөгөөд “Бэрэн групп” ХХК-ийн санал болгосон хэлцлийн хүрээнд хөрөнгийн үнэлгээ урьдчилсан байдлаар 63,695,574,524 төгрөг байна. Өнөөдрийн байдлаар “Бэрэн металл” ХХК-ийн хувьцаанаас “Бэрэн групп” ХХК -75%, Гэндэнжамцын Мөнхбилэг-25%-ийг тус тус эзэмшиж байна.

Монгол Улсын Хөгжлийн банк нь Засгийн газрын 2013 оны 256 дугаартай “Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих тухай” тогтоол, 2014 оны 41 дугаартай тогтоолын дагуу “Мон-Лаа” ХХК-ийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт байрлах “Элстэйн”

ордын төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр барих төслийг санхүүжүүлэх зориулалтаар тус компанид 2014 оны 8 дугаар 5-ны өдрийн 3-ТХ-ХО 2014-118 дугаартай “Зээлийн гэрээ”-ний дагуу нийт 3,000,000.0 (гурван сая) ам доллартой тэнцэх 5,642,970,000 (таван тэрбум зургаан зуун дөчин хоёр сая есөн зуун далан мянган) төгрөгийн зээл олгосон.

“Мон-Лаа” ХХК нь зээлийн гэрээний дагуу зээлийн төлбөрийг 2015.12.11-ээс эхлэн улирал бүр, зээлийн хүүг 2014.09.11-ний өдрөөс эхлэн сар бүр төлөхөөр үүрэг хүлээсэн боловч зээлийн хүүгийн төлбөрийг 2014.12 сараас хойш, үндсэн төлбөр, нэмэгдүүлсэн хүүг 2015.12 сараас хойш өнөөдрийг хүртэл төлөөгүй, гэрээний зөрчил үүсгэсэн.

Иймд, 2019 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд 8,203,024,259 (найман тэрбум хоёр зуун гурван сая хорин дөрвөн мянга хоёр зуун тавин есөн) төгрөгийг “Мон-Лаа” ХХК /Зээлдэгч/ болон “Их үүсгэл” ХХК /Барьцаа хөрөнгийн эзэн/-аас гаргуулах нэхэмжлэлийг 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 2/326 тоот албан бичгээр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан.

“Мон-Лаа” ХХК нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн тул 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Хөгжлийн банк, “Мон-Лаа” ХХК-ийг төлөөлж хувьцаа эзэмшигч, Ерөнхий захирал Х.Энхсайхан, Их үүсгэл ХХК-ийг төлөөлж хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга Ц.Мянганбаяр нартай Эвлэрлийн гэрээ байгуулж, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 181/ЛШЦ2019/01274 дугаартай шүүгчийн захирамжаар тус гэрээг баталж, иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Эвлэрлийн гэрээний дагуу “Мон-Лаа” ХХК нь 2019.11.30-ны дотор буюу нийт 7 сарын хугацаанд төлбөр төлөх хуваарьтай байсан боловч 6 сараас эхлэн төлбөрөө төлөөгүй тул МУХБ-аас гаргасан хүсэлтийн дагуу албадан гүйцэтгэх ажиллагааг эхлүүлсэн боловч “Мон-Лаа” ХХК-аас барьцаа хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгох нэхэмжлэлийг шүүхэд гаргаснаас шалтгаалан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түдгэлзээд байна.

**8. 2017 онд “Бэрэн групп” ХХК-д орон сууцны хороолол барих Хөгжлийн банкны 2 дахь зээлийг /11.7 сая.ам доллар/ яагаад нэмж олгосон талаар**

Нийслэлийн засаг даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/177 тоот захирамжаар “Бэрэн групп” ХХК нь Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт орон сууцны 7 дугаар хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ХЕТ-2013-1 багц Ё блок-д гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсныг батламжилж, батламж олгосон байна.

Нийслэлийн засаг даргын 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн А/604 тоот захирамжаар “Бэрэн групп” ХХК нь Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт орон сууцны 7 дугаар хороолол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ХЕТ-2013-1 багц “В, Д, Й, К, Г” блокод гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсныг батламжилж, батламж олгосон байна.

“Бэрэн групп” ХХК-ийн 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 171 тоот албан бичгээр “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтод хөтөлбөр”, “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах”, “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд СБД-ийн 11, 12-р хорооны нутаг дэвсгэрт Орон сууцны 7-р хорооллын Ё блокт хамаарах 720 айлын орон сууцны 6 барилга, шинээр баригдах 120 айлын 16 давхар 1 барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 18.0 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг БНХАУ-ын Хөгжлийн банкны гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд чиглэсэн санхүүжилтээс шийдвэрлэх хүсэлтийг ирүүлжээ.

Дээрх батламж, хүсэлтийн дагуу холбогдох судалгаа, шинжилгээг хийж Төслийн санхүүжилт, Зээлийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Зээлийн шинжилгээний танилцуулга, Хуулийн хэлтсийн 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 2017/81 дугаартай Хууль зүйн дүгнэлт, мөн Эрсдэлийн үнэлгээ удирдлагын газрын 2017 оны 9 дүгээр сарын

'27-ны өдрийн 1/17/098 дугаартай эрсдэлийн дүгнэлтэд үндэслэн 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн ЗУХ-ны хуралд танилцуулан, 2017/87 дугаартай дүгнэлт, 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн ТУЗ-д танилцуулах Зээлийн шинжилгээний танилцуулгаар ТУЗ-ийн хуралд танилцуулан 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 7 дугаар тэмдэглэлээр шийдвэрийг баталгаажуулан, 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдөр З-БГ-ЗҮ 2017-180 дугаартай Зээлийн гэрээг байгуулан тус зээлийг дараах байдалтай олгосон байна.

№	Огноо	Валют	Олгосон дүн	Төгрөгөөр	Олголтын үеийн хаш	Тайлбар
1	2017.10.30	USD	7,358,314	18,073,565,216	2,456.21	Төсөл хэрэгжүүлэгчийн "Бэрэн констракшн энд автомэшин" ХХК-тай байгуулсан "Барилгын дотоод засал болон бүрэн дуусгалын ажил гүйцэтгүүлэх гэрээ" болон "Барилгын ажил гүйцэтгэх гэрээ"-нд үндэслэн гэрээний 47% болон 60%-ийн урьдчилгаа үнэ болох 7,358,314.32 ам.долларын санхүүжилтийг 2017.10.30-ны өдөр олгосон.
2	2017.12.28	USD	1,432,864	3,478,134,608	2,427.4	Төсөл хэрэгжүүлэгчийн "Бэрэн констракшн энд автомэшин" ХХК-тай байгуулсан "Барилгын гадна фасад болон дээврийн ажил гүйцэтгэх гэрээ"-нд үндэслэн 5-р блокийн 6 барилгын гадна фасад болон дээврийн ажилд 2017.12.28-ны өдөр 1,432,864.22 ам.долларын санхүүжилтийг олгосон.
3	2018.01.18	USD	2,861,048	6,937,125,743	2424.68	Барилгын ажил гүйцэтгүүлэн гэрээ, барилгын дотоод засал болон бүрэн дуусгалын ажил гүйцэтгэх гэрээний 5-р блокийн ажлын 25%-д 2018.0118-ны өдөр 2,861,047.95 ам.долларын санхүүжилтийг олгосон.
Цуцт			11,652,227	28,488,825,567		

### 9. Хөгжлийн банк нэмж зээл олгосон нь 2014 онд тус компанид Төмөрлөгийн үйлдвэр барих зориулалтаар өмнөх олгосон зээл хэвийн явж байсан нотолгоо болох эсэх талаар

Орон сууцны хороолол барих төсөлд зориулан зээлийг олгох үед барилгын арматурын зээл нь төлбөрийн зөрчилгүй, зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулсан байсан байна. Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан, эргэн төлөлтийн хуваарийг дараах байдлаар өөрчилж байсан байна. Үүнд:

Д/д	Огноо	Тушаалын шийдвэр, дүгнэлтийн огноо дугаар	Утга	Баталгаажуулсан гэрээ, хэлцэл
1	11/25/2014	ЗУХ-ны 2014.11.25-ны өдрийн 2014/136 дугаар дүгнэлт	З-АҮ-ХО 2014-11-1 тоот Зээлийн гэрээний 2.1.5.1 дэх заалтын дагуу үлдэгдэл санхүүжилт болох 4,872,000 төгрөгийг олгох.	З-АҮ-ХО 2014-11 дугаартай Зээлийн гэрээгээр 22.7 сая ам.долларыг олгохоор шийдвэрлэж, 2014.04.16-ны өдөр 12.8 сая ам долларыг олгож, үлдэгдэл санхүүжилтийг 2014.11.28-ны өдөр тус шийдвэрийг үндэслэн олгосон байна.
2	12/25/2014	ЗУХ-ны 2014.12.25-ны өдрийн 2014/153 дугаартай шийдвэр ГЗ-ын 2015.03.02-ны өдрийн А-23 дугаар тушаал	Нэмэгдүүлсэн хүүг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу гүйцэтгээгүй үүргийн дүнгээс тооцож авах.	З-АҮ-ХО 2014-11 дугаартай Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, З-АҮ-ХО 2014-11/2 дугаартай гэрээг байгуулж, холбогдох заалтуудыг нэмэлтээр оруулсан байна.
3	12/24/2015	ЗУХ-ны 2015.12.24-ний 2015/115 дугаартай шийдвэр	Эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг Барьцаанд бариулсан хоронго тус бүрийг шинэчлэн үнэлсний үндсэн дээр дахин хэлэлцэхээр болсон.	-
4	12/2/2016	ЗУХ-ны 2016.12.02-ны өдрийн 2016/96 дугаартай шийдвэр, ТУЗ-ын 2016.12.09-ний өдрийн 108 дугаар тогтоол	Зээлийн зориулалтыг "Барилгын арматурын үйлдвэр" төслийн санхүүжилтэд зориулагдана, Зээлийн гэрээний хугацааг 2022.10.15-ны өдөр болгон оорчилсон. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ажлын гүйцэтгэлийн тайлан болон нэхэмжлэхийг үндэслэн зээлийг хэсэгчлэн олгохоор шийдвэрлэсэн байна.	З-АҮ-ХО 2014-11 дугаартай Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, З-АҮ-ХО 2014-11/3 дугаартай гэрээг байгуулж, холбогдох заалтуудыг нэмэлтээр оруулсан байна.

**10. Хөгжлийн банк 2018 онд “Бэрэн групп” ХХК-д 3 дахь зээл болох Төмөрлөгийн үйлдвэрийн эргэлтийн зээл /4.5 сая ам.доллар/ олгох шийдвэр гаргахад тус үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байсан эсэх**

“Бэрэн групп” ХХК нь 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 29 тоот албан бичгээр “МУ-ын ЗГ-ын 2013 оны 256 дугаар тогтоолын дагуу “Барилгын арматурын үйлдвэр барьж байгуулах” төслийн жилийн 200,000 тонн ган цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн эхний шугамын тоног төхөөрөмжүүдийн угсралт дууссан бөгөөд 2018 оны 5-р сард нээлтээ хийхээр төлөвлөж байгаагаар дурдан уг шугамыг ажиллуулахад шаардлагатай түүхий эд материал болон бусад шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэхээр 15.0 сая ам.долларыг 3 жилийн хугацаатайгаар олгох хүсэлтийг банканд ирүүлжээ. Ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох судалгаа, шинжилгээг хийж 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Зээлийн шинжилгээний танилцуулгыг боловсруулсан байна. Тус танилцуулгын санал, дүгнэлт хэсэгт “...үйлдвэр ашиглалтад орох хугацаа болон борлуулалтын хугацаатай уялдуулан хуримтлагдсан хүүгийн төлбөрийг хойшлуулах” саналтай байгаагаар дурдсан байна.

Мөн Эрсдэлийн Үнэлгээ Удирдлагын газрын 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 1/18/050 дугаартай дүгнэлтийн 3.2-р хэсэгт “Уг төсөлд нийт 66.2 сая ам.долларын санхүүжилт шаардлагатай бөгөөд “Бэрэн групп” ХХК нь 26.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж МУХБ-аас 22.7 сая ам.доллар болон Японы олон улсын хамтын ажиллагааны банкнаас 17.5 сая ам.долларын санхүүжилт авахаар төлөвлөсөн боловч өнөөдрийн байдлаар ЯОУХАБ-наас хоёрдугаар шугам буюу үйлдвэрийн ЕАФ шугамыг худалдан авах санхүүжилт хийгдээгүй буюу хөрөнгө оруулалтын нөхцөл байдал тодорхойгүй байгаа болно. Ингэснээр төслийн ТЭЗҮ-д дурдсан техник технологийн горимын дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явах боломжгүй байдал үүссэн бөгөөд цаашид суурилуулалтын тохиргоо хийх явцад техник тоног төхөөрөмжүүд өөрчлөх, нэмэлт шаардлагатай тоног төхөөрөмж, эд ангиуд шаардагдах, үйлдвэрлэл хэвийн явагдах нөхцөл бүрдэхгүй байх зэрэг үйл ажиллагааны эрсдэл өндөр” гэж дүгнэсэн байна. Иймд дээр танилцуулга, дүгнэлтээс харахад тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлээгүй байсан байна.

**11. “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолын хэрэгжилтийн өнөөгийн байдал, үр дүнгийн талаар**

Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 219 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 441 дүгээр тушаалыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тооцоо нийлж, өглөг авлагыг харилцан суутгах ажлыг гүйцэтгэсэн байдаг.

**12. “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилтийн өнөөгийн байдал, үр дүнгийн талаар**

Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 42 дугаар тогтоолоор Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банктай байгуулсан холбогдох гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, дуусгавар болгох, баримт бичгийг хүлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.



Уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн банк дахь 385 зээлийн дансанд үлдэгдэлтэй байсан нийт 3481 төсөл арга, хэмжээний 1,456,469,355,062.80 төгрөг болон 667,026,652.96 ам.доллар буюу нийт 3,117,052,218,406.31 төгрөгийн үндсэн зээлийн багцыг дараах төслийн захиалагч талуудад шилжүүлэх ажил хийгдсэн.

д/д	Захиалагч тал	Төсөл, арга хэмжээ	2016.12.31-ний байдлаарх үлдэгдэл санхүүжилтийн дүн		
			MNT	USD	Нийт (₮)
1	Эрчим хүчний яам	50	278,573,449,657.16	172,340,886.53	707,621,256,900.19
2	Барилга, хот байгуулалтын яам	37	170,377,284,869.70	323,316.78	171,182,191,693.01
3	Зам, тээврийн хөгжлийн яам	86	767,908,988,686.80	351,988,609.67	1,644,195,192,118.55
4	Гаалийн ерөнхий газар	2	-	19,136,545.41	47,641,003,894.56
5	Шадар сайд	1	19,966,279,138.00	-	19,966,279,138.00
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	1	2,000,000,000.00	-	2,000,000,000.00
7	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	3	3,783,266,939.00	4,135,627.41	14,079,035,445.02
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	7,995,000,000.00	-	7,995,000,000.00
9	Сангийн яам				
	Төрийн банк (6%)	1	-	58,392,830.78	145,370,704,011.73
	Эрдэнэс Оюу толгой ХХК	1	-	2,512,000.20	6,253,699,857.91
10	Нийслэлийн засаг даргын тамгын газар				
	Нийслэлийн авто замын газар	45	19,882,308,060.70	53,802,951.32	153,826,369,460.38
	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар	25	57,302,004,632.66	-	57,302,004,632.66
11	Гудамж төслийн нэгж (дараагаар төслийн нэгж өөрчлөн байгуулагдаж СЯ-ны харьяанд шилжсэн)	95	128,680,773,078.78	4,393,884.86	139,619,481,254.30
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>348</b>	<b>1,456,469,355,062.80</b>	<b>667,026,652.96</b>	<b>3,117,052,218,406.31</b>

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн тэмдэглэлээр "348 төсөл, арга хэмжээнээс өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, төсөвт өртөг, хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэсэн ажлын чанар, хэрэгжислт болон хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэх байдалд нарийвчилсан хяналт шалгалт хийхийг холбогдох сайд нар болон Нийслэлийн засаг даргад" даалгасан байдаг.

---000---

<sup>1</sup> Үүнд 2016.12.31-ний өдрийн байдлаар зөвхөн санхүүжилтийн үлдэгдэлтэй байгаа төслүүд багтсан болно. Өөрөөр хэлбэл улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт нь олгогдоод төлөгдсөн эсвэл захиалагчийн хүсэлтээр цуцлагдсан төслүүд тусгагдаагүй болно. Мөн гэрээ байгуулсан боловч санхүүжилт олгогдож эхлээгүй төслүүд багтаагүй болно.